



P.O.Box 36/10  
Ulaanbaatar  
Mongolia



## International School of Ulaanbaatar Улаанбаатар Дахь Олон Улсын Дунд Сургууль

Tel: 976-70160010/70160020  
Fax: 976-70160012

E-mail: [administration@isumongolia.edu.mn](mailto:administration@isumongolia.edu.mn)  
Website: [www.isumongolia.edu.mn](http://www.isumongolia.edu.mn)



### ОУДС танай гэр бүлийн хэрэгцээг хангаж чадах уу? ОУДС-ийн Танилцуулга

Танай хүү/охинд ОУДС-иас олгох боловсролын талаар уншиж танилцаж ойлгосоноо батлан өөрсдийн хариултыг дугуйлж гарын үсгээ зурна уу. Энэхүү товч танилцуулга нь манай сургуулийн үйл ажиллагаа, сургалтын тухай мөн бусад олон улсын болон монгол улсын ерөнхий боловсролын дунд сургуулиудаас манай сургууль ямар онцлог ялгаатай талаар та бүхэнд дэлгэрэнгүй мэдээлнэ. Та дараах зүйлсийг уншаад “дэмжиж байна” гэсэн хариултыг дугуйлсан бол ОУДС таны хүүхдэд яг тохирох сургууль байна гэж ойлгож болно.

1. ЭРХЭМ ЗОРИЛГО – Хамгийн чанартай боловсрол эзэмшүүлэх.  
*ОУДС-ийн Эрхэм Зорилгыг би дэмжиж байна/хүлээн зөвшөөрч байна/чухалчилж үзэхгүй байна/зөвшөөрөхгүй байна*
2. ЗОРИЛГО – Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын хөтөлбөрөөр дамжуулан сурагчдад хамгийн чанартай боловсрол олгож сурагчдыг насан туршдаа суралцдаг, бусдын соёл заншлыг хүндэтгэдэг, бусдад тусалдаг, аливаад хүлээцтэй ханддаг иргэд болгон хүмүүжүүлэх нь ОУДС-ийн нийт хамт олны гол зорилго юм.

*ОУДС-ийн Зорилгыг би дэмжиж байна/хүлээн зөвшөөрч байна/чухалчилж үзэхгүй байна/зөвшөөрөхгүй байна.*

3. ОУДС-д өөр өөр соёл заншилтай хүмүүс хамтран ажилладаг. Танай хүү/охинтой нэг ангид гадаадын олон орны хүүхдүүд цуг сурна. Манай сургуулийн хамт олны гишүүн нэг бүрийн соёл заншил, эрхэмлэх зүйлс, итгэл үнэмшлийг бид хүндэтгэж үзнэ. Тус сургууль зориуд гадаадын олон орнуудаас өндөр ур чадвартай мэргэжлийн багш нарыг сонгон шалгаруулж ажиллуулдаг.

*ОУДС-дээрх олон орны өөр өөр соёл заншлыг би дэмжиж байна/хүлээн зөвшөөрч байна/чухалчилж үзэхгүй байна/зөвшөөрөхгүй байна*

4. ОУДС нь Олон Улсын Бакалауриатын байгууллагын Бага, Дунд Сургуулийн болон Дипломын хөтөлбөрүүдийг заах эрхийг авсан. Энэ нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын хамгийн шилдэг аргыг дэмжсэн барууны сургалтын хөтөлбөр юм. Энэ нь эрэлхийлэх, **судлан шинжлэх, багаар ажиллах, болон сурах үйл явцад** голлон анхаардаг хөтөлбөр юм. Ойлголт авах, ур чадвараа хөгжүүлэх, арга барил олж авах зэрэг нь Хөтөлбөрийн гол онцлог юм.

*ОУДС-ийн сургалтын хөтөлбөрийг би дэмжиж байна/хүлээн зөвшөөрч байна/чухалчилж үзэхгүй байна/зөвшөөрөхгүй байна*

5. ОУДС-ийн олгож буй боловсрол нь Олон Улсын Бакалауриатын Байгууллагын зорилго, үзэл баримтлал, сургалтын агуулга дээр үндэслэгдсэн. Бид сурагчдад цогц боловсрол олгодог. Сурлагын амжилтыг сурагчдыг олон талаар нь хөгжүүлэхтэй ижил түвшинд чухалчлан авч үздэг. Бид сурагчдыг эрэлхийлэгч, өргөн мэдлэгтэй, сэтгэгч, үзэл бодлоо зөв, чөлөөтэй илэрхийлэгч, ёс журамтай, бусдын үзэл бодолд хүндэтгэлтэй хандагч, өөртөө итгэлтэй, зоригтой, өв тэгш, халамжтай, дүгнэн бодогч иргэн болгох зорилготой. Олон Улсын Бакалауриатын Байгууллагын танилцуулгыг энд хавсаргалаа.

*ОУДС-нь цогц боловсрол олгох, ОУББ сургалтын агуулгыг голлон анхаардагийг би дэмжиж байна/хүлээн зөвшөөрч байна/чухалчилж үзэхгүй байна/зөвшөөрөхгүй байна*

6. ОУДС нь олон орны багш, ажилтан, сурагчид, эцэг эхчүүдээс бүрдсэн хамт олон юм. Тус хамт олны төлөөллөөс бүрдсэн ОУДС-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл сургуулийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг. Гэр бүлийн гишүүн нэг бүр сургуулийн үйл ажиллагааг болон эрхэмлэдэг зүйлсийг хүндэтгэн дэмжих үүрэгтэй ба, сургуулийн хөгжилд өөрсдийн бүтээлч хувь нэмрийг оруулах эрхтэй.

*ОУДС-ийн хамт олны нэг гишүүний хувьд сургуулийн үйл ажиллагаа, эрхэмлэдэг зүйлсийг би дэмжиж байна/хүлээн зөвшөөрч байна/чухалчилж үзэхгүй байна/зөвшөөрөхгүй байна*

7. Сурагчдын сурлагын амжилтын нэг чухал салшгүй хэсэг нь сургууль гэр бүлийн хоорондын хамтын ажиллагаа гэж ОУДС үздэг. Иймээс бид эцэг эхчүүдийг Сургуулийн Нээлттэй Хаалганы өдөр, Эцэг Эхчүүдийн Мэдээллийн өдөр, Багш Эцэг Эхчүүдийн уулзалт болон сургалтын бусад арга хэмжээнд идэвхтэй оролцож сургуулийн үйл ажиллагааг дэмжихийг хүсдэг.

*Эцэг эхийн хувьд хүүхдийнхээ сургалтыг дэмжин сургуулиас зохиох олон төрлийн арга хэмжээ, уулзалтанд оролцох явдлыг би дэмжиж байна/хүлээн зөвшөөрч байна/чухалчилж үзэхгүй байна/зөвшөөрөхгүй байна*

8. Интернационализм болон бусад орны соёл заншлыг ойлгож хүндэтгэхийг бид эрхэмлэдэг. ОУДС-д амжилттай суралцагчид нь бусад орны хүүхдүүдтэй болон англи хэлний түвшин нь өөр өөр сурагчидтай найз нөхөд болох явдлыг дэмждэг. Зөвхөн өөртэйгээ адилхан хүмүүстэй нөхөрлөхийг хүсдэг сурагчдын хувьд ОУДС-д суралцахад хүндрэлтэй байх болно.

*Хүүхдээ олон өөр соёл заншилтай хамт олны дунд орохыг би дэмжиж байна/таашааж байна/хайхрахгүй байна/санаа зовж байна.*

9. Манай сургууль сурагчид хэлний түвшингээрээ ялгаатай байдгийг ойлгож тусалдаг. Бид Англи хэлээр сургалтаа явуулдаг ба төрөлх хэл нь Англи хэл биш сурагчдад үндсэн хичээлүүддээ оролцоход нь туслах зорилгоор англи хэлний нэмэлт хичээл заах ESL салбартай. Нэг ангийн сурагчдын Англи хэлний түвшин нь анхан шатнаас эхлээд төрөлх Англи хэлний түвшин хүртэл өөр өөр байна.

*ОУДС-н сурагчдын хэлний түвшингийн ялгаатай байдлыг би дэмжиж байна/хүлээн зөвшөөрч байна /чухалчилж үзэхгүй байна/зөвшөөрөхгүй байна.*

10. Сургуулийн өмнөх ангиас эхлээд 12-р анги хүртэл бүх сурагчиддаа бид “Монгол хэл ба Монголын соёл” хичээл заадаг. ОУДС нь Сургуулийн өмнөх ангиас 12-р анги хүртэл Англи хэлийг үндсэн хэл, 9-12-р ангиудад Солонгос, Монгол хэлийг үндсэн хэлний хичээл болгож заадаг. Гадаад хэлний хичээлээр Сургуулийн өмнөх ангиас 5-р анги хүртэл Монгол хэл, 6-12-р анги хүртэл Франц хэл, 6-9-р ангиудад Хятад хэлийг тус тус судалдаг. Төрөлх хэлийг дэмжих зорилгоор гадаад хэлний хичээлийн үеэр эцэг эхчүүд хүүхэддээ цагийн багш хөлслөн авч эх хэлээ заалгахыг зөвшөөрдөг. Манай сургууль цөөхөн сурагчтай жижиг сургууль тул одоо судалж буй гадаад хэлнүүдээс өөр олон төрлийн гадаад хэл судлах боломж байхгүй.

*ОУДС-д заагдаж буй үндсэн болон гадаад хэлний хөтөлбөрийг би дэмжиж байна/хүлээн зөвшөөрч байна/чухалчилж үзэхгүй байна/зөвшөөрөхгүй байна.*

ОУДС-ийн танилцуулгыг би уншиж, ойлгож, бөглөж дуусгав.

ГАРЫН ҮСЭГ: \_\_\_\_\_

ЭЭЖ

ААВ

/...../...../...../

